



Open Society Forum



The Embassy of Great Britain and  
North Ireland in Ulaanbaatar



Taiwan Foundation for  
Democracy

**2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр телевизийн мэтгэлцээнээр  
хөгжлийн асуудлыг тусгасан нь**

**Мониторингийн тайлан**



**“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага**

Produced by Globe International in the  
framework of the project “Increasing Voter  
Knowledge Through Journalism Writing and  
Improved Reporting”

## Гарчиг

Оршил	2-3
Хэрэгцээ, шаардлага	4-5
Мониторингийн зорилго, арга зүй	5-8
Мониторингийн дүн	8-24
Дүгнэлт, зөвлөмж	25-28

Мониторингийн баг:

Багийн ахлагч: Ч. Чойсамба, Сэтгүүл зүйн доктор, дэд профессор, МУИС  
[choisamba@yahoo.com](mailto:choisamba@yahoo.com)

Гишүүд: Доктор Л. Ариун, ХИС [l.ariun@yahoo.com](mailto:l.ariun@yahoo.com)  
Докторант М. Наранмандах, КУДС  
[naranmandakh\\_2007@yahoo.com](mailto:naranmandakh_2007@yahoo.com)

## I. Оршил

Та бүхэнд “2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр телевизийн мэтгэлцээнээр хөгжлийн асуудлыг тусгасан нь” мониторингийн тайланг толилуулж байна. Бид энэ мониторингийг “Сэтгүүл зүйн чанарыг сайжруулан сонгогчдын мэдлэгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд бэлтгэсэн юм. Энэ дашрамд манай сонгуулийн хөтөлбөрийг дэмжсэн Нээлттэй Нийгэм Форум, Монгол дахь Их Британи, Умард Ирландын Элчин сайдын яам, Тайваны ардчиллын санд талархал илэрхийлье.

Монгол Улс 2008 онд тав дахь удаагаа ардчилсан сонгууль явуулав. Сонгуулийн кампанит ажлын явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдол улам өндөр болдог. Энэ үеэр нам, нэр дэвшигчдийн сурталчилгаандаа хэвлэл мэдээллийг ашиглах хүсэл сонирхол ч нэмэгдэж, ихээхэн хөрөнгө мөнгө зарцуулдаг. Нөгөө талаар, хэвлэл мэдээлэл тэдэнд боломж олгож, шударга өрсөлдөөнд дууддаг. Энэ нь сонгогчдын сонголтод нөлөөлдөг учир хэвлэл мэдээлэлд хариуцлагатай хандах нь улс төрчдийн бас нэг үүрэг билээ.

Хэвлэл мэдээлэл нь олон түмний индэр болохын хувьд сонгуулийн үеэр улс орны хөгжлийн тулгамдсан, гол асуудалд анхаарал хандуулж, тэдгээрийн талаар улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн баримталж буй бодлого, чиглэлийн тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг эрмэлздэг. Ийм учраас хэвлэл мэдээлэл сэтгүүл зүйн хамгийн үр өгөөжтэй арга хэлбэрийг ашигладаг билээ. Харин хэвлэл мэдээллийн байгууллага бүр үүнд өөр өөрийн байр суурьтай ханддаг тул тэдний нийтэлж, нэвтрүүлсэн материал нь агуулга, хэлбэр, хандлагаараа өөр өөр байдаг. Ингэхдээ сэтгүүл зүйн мэргэжлийн стандарт буюу хэм хэмжээг хэрхэн баримталж, аль хэр мэргэжлийн түвшинд ажилласан нь сонгогчдод өгч буй мэдээллийн чанарт нөлөөлөх нь мэдээж. Энэ удаа ч манай хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийн сурталчилгаанд голлох үүрэгтэй оролцлоо.

Бид анх удаа Монголын хэвлэл мэдээлэл сонгуулийн үеэр хөгжлийн тулгамдсан гол асуудлыг хэрхэн тусгасанд мониторинг хийсэн юм.

Мониторингийн баг нь манай байгууллагаас 2008 оны 6-р сарын 7-ноос 10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Телевизээр сонгуулийн мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ?” сэдэвт сургалтад хамрагдсан, сэтгүүл зүйн мэргэжлийн багш нараас бүрдсэн юм.

Мониторингийг хийхдээ сэтгүүлч, мэргэжилтнүүдийн алдаа оноог илрүүлэн шүүмжлэхээс илүү цаашдын ажилд нь тус нэмэр болно гэх үүднээс хандсан тул

тайланг анхааралтай уншиж, санаа бодлоо илэн далангүй илэрхийлэхийг чин сэтгэлээсээ хүсч байна. Тайлангаас та бүхэн мэтгэлцээний сонгодог загвар, хэлбэр, бүтэц, стандарт, зарчмын тухай зарим мэдээллийг ана гэдэгт найдаж байна.

Төслийн удирдагч Х. Наранжаргал

## II. Хэрэгцээ, шаардлага

Сонгууль бол улс орны улс төрийн амьдралын хамгийн чухал, гол зүйл явдал билээ. Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажиллахаас түүний үр дүн, улс орны ирээдүй хамаардаг.

Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үзэл бодлын индэр, мэтгэлцээний талбар болж, нэр дэвшигч, улс төрийн намуудын байр суурийг олон нийтэд ойлгуулж, зөв сонголт хийхэд туслах үүрэгтэй билээ. ХМХ-ийн бас нэг чухал үүрэг бол улс орны хөгжил, хүмүүсийн аж амьдралын сайн сайхны төлөө улс төрийн намуудын боловсруулсан мөрийн хөтөлбөрийг хараат бусаар дүгнэн шинжилж, сонгогчдод зөв ойлголт өгөх, мөн нам, нэр дэвшигчдэд тухайн асуудлаар үзэл бодлол, байр сууриа илэрхийлэх тэгш, шударга боломж олгох явдал юм.

2007 оны эцсээр Монголд 387 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байв Энэ тоо сонгууль ойртох тутам нэмэгдсээр байна. Өмнөх сонгуулиудын үеэр Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэл, Монголын хэвлэлийн хүрээлэн, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн дүнгээс харахад, хэвлэл мэдээлэл нэг талыг барьсан, ерөөсгөл мэдээлэл түгээх, эрх барьж буй намд түлхүү үйлчлэх, сонгуулийн сурталчилгааг сонгуулийн сэтгүүл зүйгээс ялгаж салгахгүйгээр мэдээний гол хөтөлбөрөөр дамжуулах, сонгогчдын боловсролд зориулсан хараат бус хөтөлбөр, материал ховор байх зэргээр мэргэжлийн бус ажиллаж, хэрэг дээрээ сонгогчдод бус, улс төрийн намд илүү үйлчилж байв.

Намуудын сонгуулийн хөтөлбөрийн харьцуулсан судалгаа, нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн, хараат бус ярилцлага гэх зэрэг сэтгүүл зүйн хараат бус материал туйлын ховор, гол төлөв намуудын төлбөрт нэвтрүүлэг сонины зай талбай, өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн эфирийн цагийг эзэлж байлаа. Мөн сонгуулийн булхай, шударга бус, хууль бус үйлдлийг илчилсэн эрэн сурвалжлах материал бараг байсангүй.

Сэтгүүл зүйн алдаа, доголдол нь сонгогчдыг зөв сонголт хийхэд нөлөөлдөггүй, харин ч төөрөгдүүлдэг. Сэтгүүл зүйн хараат бус бүтээл нь нам, нэр дэвшигчдийн төлбөрт сурталчилгаанаас илүү бодитой мэдээллийг сонгогчдод өгнө. Үүнд янз бүрийн мэтгэлцээн, хэлэлцүүлгийн материал илүү үр өгөөжтэй байдаг. Ийм ч учраас монголын сэтгүүл зүйд ийм төрөл хэлбэрийн нэвтрүүлэг, материал хүч түрж байгаа билээ. Сонгогчдод өөрийгөө таниулах, хөгжлийн асуудлын тухай байр суурь, үзэл

бодлоо илэрхийлэх тэгш, шударга боломж олгох нь эдгээр нэвтрүүлэг, материалд тавигддаг нь гол шаардлага байдаг.

2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас

нийслэл хотод оршин суудаг, сонгуулийн насны 500 хүнийг хамруулсан судалгаа хийхэд тэдний 63.3% нь халз мэтгэлцээн, 41.4% нь Намуудын мөрийн хөтөлбөрийн харьцуулсан дүн шинжилгээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс хүсдэг гэж хариулсан байв.

Иймд мониторингийн баг сонгуулийн сурталчилгааны явцад монголын телевизүүд хөгжлийн асуудлаар сонгогчдод мэдээлэл түгээсэн эсэх, тэдгээр асуудлаар мэтгэлцээн бэлтгэсэн эсэх, бэлтгэсэн бол мэргэжлийн түвшин нь ямар байсныг тодруулахаар ажилласан юм.

### **III. Мониторингийн зорилго, арга зүй**

#### **Зорилго:**

2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр монголын хэвлэл мэдээлэл улс орны хөгжлийн тулгамдсан, гол асуудлуудад аль хэр анхаарал тавьсаныг судлах

#### **Зорилт:**

- Асуудлыг хэрхэн тусгасныг телевизийн мэтгэлцээнээр дамжуулан судлах
- Телевизийн мэтгэлцээнийг аль хэр мэргэжлийн түвшинд зохион байгуулсанд дүгнэлт хийх

#### **Арга зүй:**

Мониторингийг 2008 оны 6-р сарын 12-оос 6-р сарын 27-ны хооронд буюу сонгуулийн сурталчилгаа хамгийн идэвхжсэн үеийг сонгон авч хийсэн болно.

Мониторингид МҮОНТВ, “UBS”, “ТВ-9”, “Ийгл”, “MN-25” зэрэг үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг, зах зээлд удаан хугацаанд оршин тогтнож буй, рейтинг өндөртэй сувгийг сонгон авав.

Монгол Улсын Их Хуралд нэр дэвшигч хоёр ба түүнээс дээш тооны хүн оролцсон мэтгэлцээн, хэлэлцүүлгийн хэлбэрийн нэвтрүүлгийг мониторингийн судалгааны объект болгон авсан болно.

Мониторингийг МУИС-ийн багш, сэтгүүл зүйн доктор, дэд профессор Ч. Чойсамба, ХИС-ийн багш, доктор Л. Ариун, КУДС-ийн багш, докторант М. Наранмандах нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Их Хурлаас 2008 онд баталсан Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилтууд”, УИХ-ын 2008 оны сонгуульд өрсөлдөж буй эвсэл, намууд, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн харьцуулалтыг эх сурвалж болгон дараахь 16 сэдвийг хөгжлийн гол асуудал хэмээн тодорхойлсон болно. Үүнд:

1. Ядуурал
2. Боловсрол: бүх нийтийн анхан шатны боловсрол, дээд боловсрол гэх мэт
3. Эрүүл мэнд: эх нялхсын эндэгдэл, халдварт өвчин, ДОХ гэх мэт
4. Байгаль орчин
5. Авлига, хүнд суртал
6. Хүний хөгжлийн асуудал. Тухайлбал, нийгмийн халамж
7. Засаглалын асуудал: хууль эрх зүй, шударга ёс, нутгийн удирдлага
8. Эдийн засгийн хөгжлийн асуудал: үнийн хөөрөгдөл, мөнгөний ханш уналт, ажилгүйдэл, үндэсний үйлдвэрлэл, ажлын байр, дэд бүтэц гэх мэт
9. Хөдөө аж ахуйн хөгжлийн асуудал: хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан гэх мэт
10. Уул уурхай, ашигт малтмал
11. Иргэний эрх, эрх чөлөө: тухайлбал хэвлэлийн эрх чөлөө
13. Жендер: улс төр, шийдвэр гаргах төвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, гэр бүл гэх мэт
14. Шинжлэх ухаан
15. Тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал
16. Даяаршил: түншлэл гэх мэт

Мэргэжлийн түвшний дүгнэлтийг хийхдээ дараахь хэмжүүрийг гол үзүүлэлт болгов. Үүнд:

**1. Сэдэв.** Нэр дэвшигч тухайн сэдэвт ач холбогдол өгч, голлон ярьж байгаа эсэх, өөр сэдвийн хүрээнд дурдах төдий өнгөрч байгаа эсэхээс хамаарч үндсэн ба дам сэдэв;

**2. Баримт, үзэл бодол.** Нэр дэвшигч сэтгүүлчийн асуултанд үндсэн сэдвийн хүрээнд ярихдаа тодорхой тоо баримт, судалгааны дүнг түшиглэж, ул суурьтай хариулж байгаа эсэх, эсвэл өөрийн үзэмжээр хандаж байгааг эш болгон баримт давамгайлсан ба үзэл бодол давамгайлсан;

**3. Эх сурвалж.** Нэр дэвшигч сэтгүүлчийн асуултанд үндсэн сэдвийн хүрээнд хариулахдаа өөрийн ярьж буй мэдээллийн эх сурвалжийг дурдаж буй эсэхээс шалтгаалж эх сурвалжаа дурдсан ба эх сурвалжаа дурдаагүй;

**4. Мөрийн хөтөлбөр, өөрийн хандлага.** Нэр дэвшигч сэтгүүлчийн асуултанд үндсэн сэдвийн хүрээнд хариулахдаа намынхаа мөрийн хөтөлбөрт тулгуурлаж байна уу, эсвэл өөрийн байр суурь, хандлагыг илэрхийлж байна уу гэдгийг харгалзан намынхаа мөрийн хөтөлбөрийг танилцуулсан, өөрийн хандлагыг илэрхийлсэн;

**5. Тодорхой хариулсан эсэх.** Нэр дэвшигч сэтгүүлчийн асуултанд үндсэн сэдвийн хүрээнд тодорхой, цэгцтэй, бүрэн дүүрэн хариулт өгч байна уу, аль эсвэл тойруулж хариулах, өөр зүйлийн тухай ярих, асуултанд хариулахгүй өнгөрч байгаа эсэхийг харгалзан тодорхой хариулсан, тодорхой хариулаагүй гэж хуваалаа.

Дээрх шалгуур нь нэр дэвшигчийн чансаа, мэдлэг, улс төрийн төлөвшил, тухайн сэдвийг эзэмшсэн байдал зэргийг илтгэх болно.

**6. Хөтлөгчийн ур чадвар:** мэтгэлцээний хэлбэрийн нэвтрүүлэг хөтөлж буй сэтгүүлчийн ур чадварыг дараах шалгуураар хэмжсэн болно. Үүнд:

- **Тэгш хандлага.** Хөтлөгч мэтгэлцээнт нэвтрүүлэгт оролцож буй хэн нэгэнд ая тал засахгүй, бүгдэд нь тэгш хандаж буй эсэхийг харгалзан тэгш ба тэгш бус,
- **Шаардлагыг мөрдүүлэх.** Хөтлөгч мэтгэлцээнд тавигдах шаардлагуудыг мөрдүүлж чадаж байгаа эсэхийг харгалзан тийм, үгүй,
- **Асуулт оновчтой.** Мэтгэлцээнт нэвтрүүлгийн үеэр хөтлөгч оролцогчдод оновчтой, өөрөөр хэлбэл хөндвөл зохих, тухайн хүн хариулах боломжтой асуулт тавьж байгаа эсэхийг харгалзан оновчтой, оновчгүй,
- **Асуулт тодорхой.** Мэтгэлцээнт нэвтрүүлгийн үеэр хөтлөгч оролцогчдод тодорхой, өөрөөр хэлбэл нэг сонсоод ойлгогдохуйц, товч, сунжирсан биш, нэг асуултаар нэг л зүйлийг тодруулсан асуулт тавьж байгаа эсэхийг харгалзан тодорхой, тодорхой биш гэж хуваалаа.

Сонгодог мэтгэлцээнд хөтлөгчдөд дараахь шалгуурууд тавигддаг бөгөөд тэдгээрийг мөн судалгааны хэмжүүр болгон ашигласан юм.

- ✓ Оролцогч олгогдсон минутаа хэтрүүлэхгүй байх, хэтэрсэн тохиолдолд хариултыг таслах,
- ✓ Оролцогч асуултанд хариулахгүй өөр зүйл ярьсан тохиолдолд тасалж, асуултанд хариулахыг шаардах,

- ✓ Оролцогч хэн нэгэн рүү дайрч давшлах, доромжлох зэрэг зүй бус авир гаргасан тохиолдолд таслах үүрэгтэй.

#### IV. Мониторингийн дүн

Мониторингийн явцад мэтгэлцээн, хэлэлцүүлгийн төрлийн нийт 27 нэвтрүүлгийг телевизийн таван суваг бэлтгэж, эфирт гаргажээ.

Энэ хугацаанд “MN-25” телевизээр нэг удаа, “ТВ-5” телевизээр нэг удаа, “Ийгл” телевизээр гурван удаа, “ТВ-9” телевизээр 7 удаа, МҮОНТВ 15 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг цацагдлаа. Харин “UBS” телевиз ийм хэлбэр, төрлийн нэвтрүүлэг бэлтгээгүй байна.

Мэтгэлцээний нэр, огноо, эфирт явсан цагийг дор үзүүлэв.

№	Телевиз	Нэвтрүүлэг	Өдөр	Цаг
1	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008. 6.12	21.00-22.30
2	ТВ-9	Мини парламент	2008.6.12	09.11-09.50
3	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.13	21.00-22.30
4	ТВ-9	Мини парламент	2008.6.13	21.30-22.23
5	Ийгл	Халз мэтгэлцээн	2008.6.13	10.30-11.10
6	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.16	21.00-22.30
7	ТВ-9	Мини парламент	2008.6.16	21.29-22.26
8	МҮОНТВ	Нэр дэвшигчдийн цаг	2008.6.17	19.00-20.00
9	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.17	21.00-22.30
10	MN-25	Мэтгэлцээн	2008.6.17	11.20-12.00
11	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.18	21.00-22.30
12	ТВ-9	Мини парламент	2008.6.18	21.30-22.09
13	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.19	21.00-22.30
14	ТВ-9	Мини парламент	2008.6.19	21.45-22.40
15	МҮОНТВ	Нэр дэвшигчдийн цаг	2008.6.20	19.00-20.00
16	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.20	21.00-22.30
17	ТВ-9	Мини парламент	2008.6.20	21.38-22.29
18	МҮОНТВ	Нэр дэвшигчдийн цаг	2008.6.21	19.00-20.00
19	Ийгл	Сонгууль-2008	2008.6.21	11.20-12.00
20	ТВ-9	Мини парламент	2008.6.21	21.37-22.40
21	Ийгл	Сонгууль-2008	2008.6.22	11.20-12.00
22	МҮОНТВ	Нэр дэвшигчдийн цаг	2008.6.23	19.00-20.00
23	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.23	21.00-22.30

24	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.24	21.00-22.30
25	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.25	21.00-22.30
26	ТВ-5	Халз мэтгэлцээн	2008.6.26	21.00-22.30
27	МҮОНТВ	Халз мэтгэлцээн	2008.6.27	21.00-23.00

МҮОНРТ-ийн хамтран зохион байгуулсан “Халз мэтгэлцээн”-ийг 2008 оны 6-р сарын 12-ны өдрөөс 6-р сарын 26-нд ажлын өдөр 21.00 цагаас 22.30 хүртэл, 6-р сарын 27-нд 21.00-23.00 цагийн хооронд орон даяар шууд дамжуулав.

Энэхүү халз мэтгэлцээний зорилго нь сонгуульд оролцож байгаа нам, эвслийн мөрийн хөтөлбөрт улс орны хөгжлийн тулгамдсан асуудлууд хэрхэн туссаныг гаргах, олон нийтэд танилцуулах явдал юм. МҮОНРТВ-ийн дэргэдэх судалгааны алба олон нийтийн дунд түүвэр судалгаа хийсний үндсэн дээр тэдний анхаарлын төвд байгаа, төрийн зохицуулалт, хууль-эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цогц шинэчлэл шаардсан 10 багц сэдвийг тодорхойлжээ. Тэдгээр сэдвээр 10 удаагийн цуврал мэтгэлцээн зохион байгуулж, сонгуульд өрсөлдөж байгаа 11 нам, эвслийн төлөөлөгчийг урьж оролцуулсан байна. Мөн энэ хугацаанд тус телевиз нь зөвхөн бие дааж нэр дэвшигчдийг оролцуулсан, тэдний мөрийн хөтөлбөрийг танилцуулах зорилго бүхий “Нэр дэвшигчдийн цаг” мэтгэлцээний богино нэвтрүүлэг долоон удаа цацжээ.

“ТВ-9” телевиз тодорхой нэг сэдвээр бүх нам, эвслийн төлөөлөгчдийг хамруулалгүй, нэг удаад 3-4 нэр дэвшигчийг оролцуулсан мэтгэлцээн зохион явуулж байлаа. Ингэхдээ УИХ-д нэг буюу хэд хэдэн удаа сонгогдсон хашир туршлагатай парламентчдыг сонгуульд анх удаа бие дааж нэр дэвшиж байгаа хүмүүстэй мэтгэлцүүлсэн юм.

“Ийгл” телевиз нэг тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүсээс гурваас дөрвөн төлөөлөл оролцуулснаараа өмнөх хоёр телевизийн мэтгэлцээнээс онцлогтой болжээ.

### **Мэтгэлцээний сэдэв**

Судалгаанд хамрагдсан мэтгэлцээний нэвтрүүлгүүдэд хөгжлийн тулгамдсан ямар асуудлууд дурдагдсаныг авч үзье.

**МҮОНТВ** дараах 10 сэдвийн хүрээнд сонгуульд өрсөлдөж байгаа нам, эвслийн мөрийн хөтөлбөрийн онцлогийг гаргажээ. Үүнд:

- Боловсрол,
- Мөнгөний ханш уналт,

- Гэмт хэрэг, архидалт,
- Байгаль, экологи,
- Ажилгүйдэл, ядуурал,
- Бүсийн хөгжил,
- Хүнсний аюулгүй байдал,
- Эрүүл мэнд,
- Авлига,
- Ашигт малтмал.

**“TV-9” телевиз** дараахь сэдвээр нэр дэвшигчдийн дунд мэтгэлцээн явууллаа.

Үүнд:

- Залуу гэр бүл ба орон сууц,
- Ашигт малтмал,
- Газрын харилцаа, газар өмчлөл,
- Хуулийн хэрэгжилт,
- Нийслэлийн хөгжил,
- Бизнесийн эрүүл орчин, татвар зэрэг

**“Ийгл” телевиз** зөвхөн ням гаригт мэтгэлцээн бэлтгэж, дараахь сэдвээр ярилцжээ.

- Ядуурал, ажилгүйдэл,
- Сонгууль,
- Ажлын байр

Дээрх үндсэн сэдвийн хүрээнд мэтгэлцээний үеэр хамгийн их дурдагдсан арван сэдвийг тодруулав. Үүнд:

- уул уурхай, ашигт малтмал (11,3%);
- хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага (10,3%);
- авлига, хүнд суртал (7,2%);
- байгаль, экологи (6,7%);
- хүнсний аюулгүй байдал (5,4%);
- мөнгөний ханш уналт (4,6%);
- үнийн хөөрөгдөл (4,6%);
- эдийн засгийн хөгжлийн асуудал (4,2%);

— газар өмчлөл, газрын хууль (3,8%);  
 — ажлын байр (3,0%) зэрэг байсан ба дам хэлбэрээр хамгийн олон дурдагдсан арав нь:

- хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага (16,5%);
- авлига, хүнд суртал (9,8%);
- нийгмийн халамж (6,9%);
- үндэсний үйлдвэрлэл (5,6%);
- уул уурхай, ашигт малтмал (5,5%);
- ядуурал (5,4%);
- иргэний эрх, эрх чөлөө (5,3%);
- байгаль, экологи (4,3%);
- эдийн засгийн хөгжлийн асуудал (4,1%);
- ажлын байр (3,6%) гэх мэт сэдэв байлаа.

Үүнийг давтамжаар нь авч үзье.

№	Сэдэв	Үндсэн	Дам	Нийт
1	Хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага	78	141	219
2	Авлига, хүнд суртал	55	84	139
3	Уул уурхай, ашигт малтмал	86	47	133
4	Байгаль, экологи	51	37	88
5	Үндэсний үйлдвэрлэл	22	48	70
6	Эдийн засгийн хөгжлийн асуудал	32	35	67
7	Нийгмийн халамж	8	58	66
8	Ядуурал	16	46	62
9	Ажлын байр	23	31	54
10	Иргэний эрх, эрх чөлөө	3	45	48
11	Мөнгөний ханш уналт	35	10	45
12	Хүнсний аюулгүй байдал	41	1	42
13	Татвар, зээл	14	28	42
14	Ажилгүйдэл	20	20	40
15	Боловсролын тулгамдсан асуудал	13	27	40
16	Засаглал	19	20	39
17	Газар өмчлөл, газрын хууль	29	8	37
18	Үнийн хөөрөгдөл	35	1	36
19	Хүний хөгжил	12	17	29

20	Хөдөө аж ахуй	2	23	25
21	Тусгай мэргэжлийн боловсрол	13	10	23
22	Гэмт хэрэг	11	12	23
23	Дэд бүтэц	4	17	21
24	Иргэний хяналт	2	19	21
25	Дээд боловсрол	15	3	18
26	Хөдөөгийн хөгжил (бүсийн хөгжил)	15	1	16
27	Бүх нийтийн анхан шатны боловсрол	11	4	15
28	Орон сууц	14	-	14
29	Тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал	3	10	13
30	Халдварт өвчин (ДОХ)	11	1	12
31	Дундаж наслалт	11	-	11
32	Эрүүл мэндийн даатгал	11	-	11
33	Эмнэлгийн анхан шатны үйлчилгээ	11	-	11
34	Эмнэлгийн үйлчилгээний чанар	11	-	11
35	Төсөв	3	8	11
36	Гэр бүл	5	5	10
37	Өмч хувьчлал	3	5	8
38	Нутгийн удирдлага	-	8	8
39	Газар тариалан	3	4	7
40	Хот төлөвлөлт, байгуулалт	3	3	6
41	Эрүүл мэнд	2	4	6
42	Хөрөнгө оруулалт	-	5	5
43	Шашин	3	-	3
44	Жендер	-	3	3
45	Мал аж ахуй	-	3	3
46	Аялал жуулчлал	1	-	1
47	Хэвлэлийн эрх чөлөө	-	1	1
48	Улс төр, шийдвэр гаргах төвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо	-	1	1
49	Шашин ухаан	-	1	1
		760	855	1615

Мэтгэлцээн ямар телевизээр, ямар сэдвийн хүрээнд явагдсанаас үл хамааран хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага; авлига, хүнд суртал; уул уурхай, ашигт малтмал; байгаль, экологи; үндэсний үйлдвэрлэл; эдийн засгийн хөгжлийн асуудал; нийгмийн халамж; ядуурал; ажлын байр; иргэний эрх, эрх чөлөө гэсэн

сэдэв үндсэн сэдвийн хүрээнд болон дам байдлаар хамгийн олон удаа хөндөгдсөн байна.

### **Мэтгэлцээний бүтэц, хэлбэр**

Телевиз тус бүрийн мэтгэлцээн бүтэц, хэлбэрийн хувьд өөр хоорондоо ялгаатай байв. Гэхдээ мэтгэлцээний сонгодог загварт нийцсэн гэж үзэж болно. Олон улсын сонгодог загварын дагуу оролцогчдын тэгш байдлыг хангах, тэдэнд ижил тэгш боломж олгох, тэнцвэртэй байх нь мэтгэлцээнд тавигддаг хамгийн үндсэн, чухал шаардлага юм. Үүнээс гадна мэтгэлцээнд дараахь стандартыг зайлшгүй баримтлах ёстой. Үүнд:

- Хөтлөгчтэй байх
- Мэтгэлцээний дүрмийг танилцуулах
- Оролцогсдыг танилцуулах
- Асуултад хариулахаар шодох
- Оролцогсдод адил асуулт тавих
- Хариултад хугацаа тогтоох
- Өрсөлдөгч талуудаас адил тооны хүн оролцох
- Оролцогсод мөрийн хөтөлбөрөөс халивал сануулах
- Оролцогсод асуултад хариулахгүй бол таслан зогсоох
- Мэтгэлцээнийг рекламаар таслахгүй байх

### **Мэтгэлцээний бүтэц, загварын харьцуулалт**

<b>“Халз мэтгэлцээн” (МУОНТВ)</b>	<b>“Мини парламент” (“ТВ-9”)</b>	<b>“Нээлтэй хэлэлцүүлэг” (“Ийгл”)</b>
Нэг хөтлөгчтэй	Нэг хөтлөгчтэй	Хоёр хөтлөгчтэй
Нэвтрүүлгийн дүрмийг танилцуулах (цаг, оновчтой хариулах г. м.)	Нэр дэвшигчдэд хувийн дугаар өгсөн. Үзэгч нэвтрүүлгийн явцад дэмжиж буй нэр дэвшигчийнхээ хувийн дугаарыг өгөгдсөн тусгай дугаар лүү мессежээр илгээх бөгөөд дэлгэцэн	

	дээр графикаар хэн хэдэн саналтай байгааг шууд харуулж байсан	
Оролцогчдыг товч танилцуулсан	Нэр дэвшигчдийн танилцуулга (ижил асуултанд хариулсан хэлбэрээр бэлтгэсэн танилцуулга)	Оролцогчдыг хөтлөгч товч танилцуулсан
Асуултанд хариулах дараалал сугална	Нэр дэвшигчдийн ярих дараалал байхгүй. Хэн хариулахыг хөтлөгч үзэмжээрээ шийднэ	Нэр дэвшигчдийн ярих дараалал байхгүй. Оролцогчид өөрсдөө яриад явчихдаг
Мөрийн хөтөлбөрийн дагуу хариулах ёстойг сануулах	Оролцогчийн хариултыг дэмжих, нэг оролцогчоос нэг асуултанд дахин хариулт авах, эсвэл дараалан асуулт тавих, зөвхөн нэг л оролцогчид хандсан асуулт тавьж байсан	Утсаар үзэгчдээс асуулт авч, санал бодлыг нь сонсож байсан
Нэр дэвшигчдэд дунд нь нэг л асуулт тавьдаг	Асуулт бүрт оролцогчдоос хариулт авдаггүй. Нэг асуултанд бүгдээрээ ч, хэн нэг нь ч хариулж болдог	Нэр дэвшигчдэд дунд нь нэг л асуулт тавьдаг
Оролцогчид хоёр минутанд багтааж хариулна (хонх цохино). Зарим тохиолдолд сүүлийн асуултанд нэг минутанд хариулах нөхцөлтэй	Оролцогчид 2 минутанд багтааж хариулна (хонх цохино). Цаг заадаг ч цаг дууссаны дохиог хариулт бүрт өгөхгүй байсан	Хугацаа байхгүй. Оролцогчид ярих зүйлээ дуустал хариулна
Хөтлөгч хугацаа хэтэрсэн, өөр зүйл ярьсан тохиолдолд зогсооно	Хөтлөгч хугацаа хэтэрсэн болон өөр зүйл ярьсан тохиолдолд зогсоож чадахгүй байсан	Хөтлөгч зогсоох болон бусад шаардлага тавихгүй

Сонгуульд өрсөлдөж байгаа 12 нам, эвслээс тус бүр нэг төлөөлөгч оролцоно	Бие даагч болон намын төлөөлөлтэй нэр дэвшигчдийг хамтад нь оруулдаг. Тодорхой дүрэм бариагүй. Оролцогчдын хувьд цөөхөн	Нэг тойрогт нэр дэвшиж буй цөөн нэр дэвшигчид
Мэтгэлцээний явцад ямар ч реклам сурталчилгаа цацаагүй	Мэтгэлцээний явцад ямар ч реклам сурталчилгаа цацаагүй	Дундуур нь реклам ихтэй. Мэтгэлцээний явцад улс төрийн рекламыг, тэр дотроо зөвхөн нэг намыг дагнан сурталчилсан реклам цацсан

Сонгуулийн үеэр нэр бүхий телевизийн сувгаас зохион байгуулсан мэтгэлцээнд сонгодог мэтгэлцээний үндсэн шаардлага буюу адил тэгш байдлыг зөрчсөн нь ажиглагдав. Мөн мэтгэлцээнийг рекламаар таслахгүй, хөтлөгчийн оролцоо бага байх, үзэгчдийг татахын тулд дүрслэл сайтай эхлэл, төгсгөл хийх, график оруулах, баялаг дүрс өгөх, титрийг аль болох удаан өгөх зэрэг стандарт, зарчим алдагджээ.

Тухайлбал: “Ийгл” телевизийн мэтгэлцээнд оролцогчдод тодорхой хугацаанд хариулах цаг өгөөгүйгээс оролцогч бүр өөр өөр хугацаанд хариулах, мэтгэлцээний дундуур олон тооны реклам, тэр ч байтугай улс төрийн сурталчилгаа явуулах зэрэг теле мэтгэлцээний үндсэн шаардлагуудыг зөрчсөн тохиолдол цөөнгүй байна. 2008 оны 6-р сарын 15-нд нэвтэрсэн “Ажилгүйдэл, ядуурал” сэдэвтэй мэтгэлцээний хэлбэрийн нэвтрүүлгийн дундуур нийт 3 удаа бүгд 7 минутын хугацаатай реклам цацагдсанаас улс төрийн реклам 4 байсан бөгөөд бүгд Ардчилсан намын сурталчилгаа байсан юм. Харин 6-р сарын 21, 22-ны едрийн мэтгэлцээний дундуур Ардчилсан намын сурталчилгаа 8 удаа, МАХН-ын сурталчилгаа 16 удаа цацагдсан. Энэ хоёр нэвтрүүлэг тус бүр нь 40 минут үргэлжилсэн бөгөөд 463080 дугаараас үзэгчдийн санал, асуултыг авч байсан нь мэтгэлцээний хэлбэрийн нэвтрүүлэгт зохимжгүй байлаа. Учир нь утсаар холбогдсон үзэгч мэтгэлцээнд оролцогчдын хэн нэгнийг нэр зааж илэрхий дэмжих, шүүмжлэхээс гадна санаа бодлоо цаг хугацааны хувьд хязгаарлалтгүй илэрхийлж байсан нь энэхүү нэвтрүүлгийн зорилго, ач холбогдолд сөрөг нөлөө үзүүлж байсан юм. Мэтгэлцээнд оролцогчдын үзэл бодол, мөрийн хөтөлбөр сонгогчдод чухал болохоос хэн нэг үзэгчийн байр суурь ач холбогдолгүй билээ. Түүнчлэн “Ийгл” телевизийн “Сонгууль-

2008” мэтгэлцээний эхний дугааруудад сонгуулийн нэг тухайлсан тойрогт нэр дэвшсэн нам, эвсэл, бие даагч гээд олон төлөөлөл оролцож байсан бол сонгуулийн өмнөх долоо хоногийн хоёр нэвтрүүлэгт ердөө хоёр, хоёрхон төлөөлөл оролцсон нь халз мэтгэлцээнд нэр дэвшигчдийн хандах хандлагыг тодорхой хэмжээгээр илэрхийлж байна гэж үзэж болно.

“ТВ-9” телевизийн хувьд мэтгэлцээний хөтлөгч нь оролцогч болгонд харилцан адилгүй асуулт тавих, мөн хариулах дараалал байхгүйгээс үзэмжээрээ хэн нь эхэлж ярихыг заах, оролцогчдоосоо их ярих, оролцогчийн хариултыг илэрхий, шууд дэмжих зэргээр дээрх шаардлагуудыг зөрчиж байсан. 2008 оны 6-р сарын 18-нд цацагдсан “Хуулийн хэрэгжилт” сэдэвтэй мэтгэлцээний хэлбэртэй нэвтрүүлгийг нээсэн “Хууль хэрэгжихгүй байгаагаас нийгэмд бухимдал бий болоод байна. Хууль хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан юу вэ?” гэсэн асуултыг Ардчилсан намаас нэр дэвшигч Л.Цогоос асуугаад, хариулт авсны дараа залгуулаад хоёр дахь асуултыг тавив: “Олон хүн дээрээ хууль зөрчөөд байгаа болохоор ард түмэн яаж хууль мөрдөх юм бэ гэсэн асуулт тавьдаг”. Хоёр дахь асуултанд Л.Цогоос гадна бие дааж нэр дэвшигч Т.Мэндсайхан хариулсан. Энэ болон гурав дахь асуултанд (“Хуулинд итгэх итгэл алдарчихсан. Хуулиар шийдсэнээс хахууль өгөх нь хялбар гэж боддог болсныг яаж засч залруулах вэ?”) бие даагч Д.Туяа хариулсан. Харин “Албан тушаалтны буруугаас учруулсан хор хөнөөл нийгэмд өргөн цар хүрээтэй байдаг. Гэтэл 10 мянган төгрөг хулгайлаад 10 жилийн ял авах, 10 тэрбум төгрөг хулгайлаад 10 хүрэхгүй жилийн ял авдаг. Үүнийг яаж зохицуулах ёстой вэ?” гэсэн дөрөв дэх асуултанд эхний оролцогч Л.Цог хариулсан. Тав асуултанд (“Шүүх хэний ч хараат бус байх ёстой. Гэвч шүүхэд итгэх итгэлээ ард түмэн алдчихсан. Үүнийг та юу гэж бодож байна?”) Т.Мэндсайхан, Д.Туяа нар хариулсан бөгөөд энэ мэтчилэн нэр дэвшигч бүрт хандсан асуулт тавьж, хариулт авав. “Албан тушаалтанд холбоотой хуулийн заалтыг авч хаяснаар олон гэмт хэрэг хэрэгсэхгүй боллоо. Үүний гол буруутан хэн бэ?”, “Хуулиуд хоорондоо зөрчилддөг. Энэ юутай холбоотой вэ?” гэсэн 6, 7 дахь асуултанд гурван оролцогч бүгд хариулсан бөгөөд харин Л.Цог нэг асуултанд хоёр удаа хариулт өгсөн. “Хууль ойр ойрхон өөрчилдөг. Ийм эрх УИХ-д байдаг уу?” гэсэн 8 дахь асуултанд Т.Мэндсайхан хариулсан. Асуултуудын эцэст гурван оролцогч гурвуулаа саналаа хэлсэн. Нэвтрүүлгийн төгсгөлд хөтлөгч: “Сүүлчийн асуултыг нэр дэвшигчдэд үлдээе” гэсэн нь ойлгомжгүй, учир зүйн хувьд зөрчилтэй болсон юм.

Сонгогчдод зориулсан сонгуулийн кампанийн үеийн эдгээр мэтгэлцээнээс МҮОНТВ-ийн зохион байгуулсан “Халз мэтгэлцээн” нь телевизийн мэтгэлцээний стандарт, шаардлагад ойртсон гэж үзэж байна.

МҮОНТВ-ийн “Халз мэтгэлцээн”-ий сүүлийн нэвтрүүлэгт УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдөж буй 10 нам, 1 эвслийн дарга нар оролцож, намын уриа, мөрийн хөтөлбөрөө товч танилцуулснаас гадна хэрвээ сонгогдвол юу хийх талаар мэтгэлцлээ. Тус мэтгэлцээний хугацаа нь өмнөх мэтгэлцээнүүдээс 30 минутаар илүү байв. Намын дарга нар хөтлөгч рүү хэт хандах, түүний ажлыг заах, асуултыг эсэргүүцэх, хариулахаас татгалзах зэргээр авирласан төдийгүй, оролцогч бүрт 2 минут оногдож байсныг 3 минут болгож нэмэх, хугацааг сунгах зэргээр давуу эрх эдэлж байсан нь энэхүү мэтгэлцээнийг мэргэжлийн хэм хэмжээнд явуулах боломжийг хаасан юм. Нэвтрүүлэг эхлээд нэг цаг өнгөрсний дараа хөтлөгчөөс тавьсан “Намын удирдагчийн хувьд улс төрийн намын төлөвшил нь төрийн тогтолцоонд хэрхэн нөлөөлж байна вэ? Танай нам, эвсэл засгийн эрхэнд гарвал Засгийн газраа дангаараа болон хамтарч байгуулсан тохиолдолд хэнийг Ерөнхий сайдаар сонгох вэ?” гэсэн асуултанд зарим намын дарга нар хариулахаас эрс татгалзаж, энэ нь эрх баригч томоохон намуудад хамаарах асуулт байна хэмээн эсэргүүцлээ. Гэсэн хэдий ч улс төрийн намын төлөвшлийн талаар хариулах болсноор мэтгэлцээн үргэлжлэв. Энэ хүртэлх хугацаанд хөтлөгч өөртөө итгэлтэй, зоригтойгоор оролцогчдод тавих шаардлагыг мөрдүүлж байсан бол маргааны дараагаас илтэд сул дуугаар цааш хөтлөх болсон. Асуултгүйгээр өөрсдийн ярих гэсэн зүйлээ өгөгдсөн 3 минутанд багтаан өгүүлэх хүсэлтэй оролцогч ч байлаа.

“Хөгжлийн хөтөлбөр” намын дарга Н. Зууннаст МАХН-ын дарга С. Баярт хандан “Танай нам бол оюуны чадавхиар сайн боловсон хүчин ихтэй нам. Гэвч эдгээр хүмүүсээ тэргүүн эгнээнд гаргахгүй, арын эгнээнд байлгаад байгаа хэрнээ тавьж явуулах дургүй. Баяр даргатай уулзсаных, манай намд эдгээр хүмүүсээ өгөөч ээ гэж гуйж байна” хэмээн өөрт оногдсон 3 минутандаа ярьснаас сонгуульд өрсөлдөж буй намуудын чадавхи, төлөвшил зэрэг нь үзэгч, сонсогчдод шууд тодорхой харагдаж байлаа. Н. Зууннаст нэвтрүүлэгт оролцох ямар ч бэлтгэлгүй, маш их сандарч балмагдан, юу ярих, юу хэлэхээ төдийлөн сайн мэдэхгүй байсан бөгөөд хамгийн харамсалтай нь камерын өмнө нусаа байнга татаж байв. Энэ мэтгэлцээний нэг онцлог нь оролцогчид бусад нам руу дайрах, нөгөөх нь хариу залруулга хийх, бусад мэдээллийн хэрэгсэл, сувгаар цацагдсан аливаа мэдээллийг няцаах явдал түгээмэл байлаа.

Нэвтрүүлгийн эцэст оролцогч бүрт нэг минутанд багтааж үзэгчдэд хандаж сонгуулийн сурталчилгаа хийх боломж олгосон. Гэвч зарим намын төлөөлөл ийм богино хугацаанд юу ярьж амжих юм бэ гэсээр минутаа барсан бөгөөд зүй зохистой ашиглахыг бодоогүй юм. Мөн улс төрийн сонгуульд анх удаа оролцож байгаа шинэ намуудын төлөөлөгч, дарга нар өөрт олгогдсон хугацааг бүрэн дүүрэн ашиглалгүй яриагаа хонх дуугархаас өмнө дуусгаж байлаа.

Харин “Нэр дэвшигчдийн цаг” мэтгэлцээний хэлбэрийн нэвтрүүлэг нь хэдийгээр адилхан МҮОНТВ-ээс зохиогддог ч сул болсныг дурдах хэрэгтэй. Хөтлөгч эвсэл, намуудын төлөөлөлд ердөө ганц асуулт, заримдаа нэмэлт асуулт тавиад л нэвтрүүлгийн хугацаа дуусч байх жишээтэй. Тухайлбал: 2008 оны 6-р сарын 23-нд цацагдсан нэвтрүүлгээр хөтлөгч “Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө ямар зорилго, зорилтуудыг тавьсан бэ?”, “Өөрсдийнхөө уриаг тодорхойлох уу?” гэж асуугаад хариултыг авахад нэвтрүүлгийн хугацаа дуусч байна. Энэ нэвтрүүлгээр УИХ-ын 23, 25-р тойрогт бие даан нэр дэвшигч дөрвөн хүн оролцсон юм. Тэгвэл хөтлөгч хоёр дахь асуултыг зөвхөн нэг хүнээс асуугаад, тэр нь өөр зүйл яриад эхлэхэд хоёр удаа сануулсны эцэст дараагийн нэр дэвшигчдээс асуулгүй мэтгэлцээнийг шууд хааж байна. Ер нь “Нэр дэвшигчдийн цаг” нэр төдий нэвтрүүлэг болсон юм. Энэ нэвтрүүлгийг үзсэн сонгогч бие даан нэр дэвшигчийн тухай ямар нэг мэдээлэл, ойлголт авч чадахгүй өнгөрч байлаа. Зарим өдөр “Нэр дэвшигчийн цаг”-аар мэтгэлцээн гараагүй болно.

Энэхүү халз мэтгэлцээнүүдийг асуултаар нь задалж үзэхэд нэг удаагийн нэвтрүүлэгт дунджаар 3-4 асуулт тавигдаж байснаас оновчгүй, тодорхой биш асуулт цөөнгүй байлаа. Асуулт нь өгөгдсөн 2 минутанд хариулж багтахааргүй хэтэрхий өргөн, олон утга агуулж байсан нь тус нэвтрүүлгийг зохион байгуулж буй хүмүүсийн туршлага, арга барил дутмаг байгааг харуулж байна.

Харин “ТВ-5” телевизээр 2008 оны 6-р сарын 26-нд цацагдсан, МАХН, АН-ын дарга нар оролцсон мэтгэлцээнд ийм хэлбэрийн бусад нэвтрүүлгийг бодвол хамгийн олон буюу 18 асуулт тавигджээ. Хэдийгээр мэтгэлцээний эхэнд 15 асуулт тавихаар төлөвлөж байсан ч ердөө хоёрхон оролцогчтой, асуултанд 2 минутанд багтааж хариулж байсан учир хугацаа илүү гарч, гурван асуулт нэмж тавьсан байна. Асуулт нь оновчтой, тодорхой, өргөн хүрээг хамарч чадсан гэж үзэж байна.

Энэ нэвтрүүлгийн өөр онцлог гэвэл эрэгтэй, эмэгтэй хоёр хөтлөгчтэй, мэтгэлцээнийг хэн эхлэх, төгсгөхийг намуудын сонгуулийн менежерүүд урьдчилан шодож, тус телевизтэй мэтгэлцээний зарчмыг танилцуулсан гэрээ байгуулсанд

оршино. Асуултанд хоёр оролцогч ээлжилж хариулах зарчмаар мэтгэлцээн явагдсан бөгөөд хөтлөгчид оролцогчдын нэгэн адил асуултаа ээлжлэн тавьжээ.

Ерөнхийдөө энэ нэвтрүүлэг мэтгэлцээний шаардлага, стандарт, зарчмыг хангасан, бусад телевизийнхтэй харьцуулахад илүү мэргэжлийн төвшинд хийгдсэн гэж дүгнэж байна.

Манай теле сэтгүүл зүйн түүхэнд ингэж олон мэтгэлцээн зохион байгуулсан тохиолдол байхгүй бөгөөд оролцогчдод ч, зохион байгуулагчдад ч алдаа, дутагдал байсныг тэмдэглэх хэрэгтэй.

### **Мэтгэлцээний хөтлөгч**

Зарим улс оронд мэтгэлцээний хөтлөгчид тусгайлан тавих шаардлагыг жагсааж, шалгаруулах ч явдал байдаг. Тэр ч байтугай хөтлөгч нь теле сэтгүүлч байх албагүй гэх тохиолдол бий. Тэгвэл манай телевизүүдээр цацагдсан дээрх мэтгэлцээний хөтлөгчид тухайн мэдээллийн хэрэгслийнхээ нийгэм, улс төрийн нэвтрүүлгийн редактор, сэтгүүлчид байсан бөгөөд энэ нь ололттой хийгээд дутагдалтай талтай байлаа. Дутагдалтай тал нь хөтлөгч тухайн сэдвийн хүрээнд тавьж буй асуултаа хэт нурших, санаагаа дутуу орхих, олон утга илэрхийлэх, оролцогчдын хариултыг онцлон илэрхий дэмжих, харин ололттой тал нь асуудлыг зөв чиглүүлэх, сэдвээс хазайх, халих тохиолдолд анхааруулах зэргээр илэрч байв.

Дутагдалтай талын зарим нэг жишээ дурдъя. МҮОНТВ-ээр 2008 оны 6-р сарын 23-нд нэвтэрсэн “Бүсийн хөгжил” сэдвээр зохиогдсон халз мэтгэлцээнийг хөтлөгч нээж, эхний асуултыг тавихдаа: “Улсын нийслэл Улаанбаатар хотод маань хүн амын одоо бараг талаас илүү хувь нь оршин сууж байгаа гэж хэлж болно. Тэхээр хүн амын маань өсөлт жилээр биш, өдөр цагаар ... ийм одоо бөөгнөрөл ... шуудхан хэлэх юм бол одоо ийм төвлөрөл үүсээд удаж байнаа ... гэдэгтэй та бүхэн үүнтэй санал нийлэх байх. Тэхээр төв рүү чиглэсэн их нүүдлийн хор уршиг, сүүдэртэй тал гэх юм бол их олон зүйл байгаа. За ер нь одоо манай улс орон яагаад одоо нутаг дэвсгэрээрээ яагаад жигд тэгш хөгжихгүй байгаагийн шалтгаан нь юу юм бэ? гэсэн ийм асуулт гарч ирж байгаа. Тэхээр одоо ийм байдлаас яаж гарах вэ гэхээр бүсийн хөгжил өө гэж хариулах хүн олон байгаа. Та бүхэн энэнтэй одоо санал нийлэх байх аа гэж ... ингэж бодож байна. Тэхээр бүсийн хөгжлийн тухай зайлшгүй ярих ёстой болсон ийм шалтгаануудыг та бүхэн юу гэж олж үзэж байгаа бол? Энэ талаар эхлээд одоо асуултыг авья гэж бодож байна” гэнэ. Тоо баримт, найруулгын маш олон алдаа мадагтай энэ асуултыг нэг сонсоод ойлгоход түвэгтэй байв. Ер нь иймэрхүү бүрхэг, ойлгомжгүй асуулт олон

байлаа. Зүй нь сэтгүүлч урьдчилаад бэлтгэсэн асуултыг оролцогчдод уншиж өгөх хэрэгтэй байсан юм. Ихэнх асуултыг сонсоод яг ийм зүйл асуулаа гэж ойлгоход бэрх, харин нэг иймэрхүү л юм асууж байх шиг байна гэж тойм төдий барагцаалан төсөөлөхөөс өөр арга байсангүй. Тодорхойгүй асуулт тодорхой хариулт өгөхөд хүндрэл учруулдаг нь ойлгомжтой.

Мөн нэг асуултыг ялимгүй хувиргаж, хэдэнтээ асууж байна. Тухайлбал: 2008 оны 6-р сарын 24-нд цацагдсан “Хүнсний аюулгүй байдал” сэдвээр зохиогдсон мэтгэлцээнд хөтлөгч: “Монгол улс ер нь болбол ... та бүхэн мэдэж байгаа байх ... хүнснийхээ бүтээгдэхүүнийхээ одоо ихэнх зүйлийг ... за ер нь бараг ... зарим хүмүүсийн одоо дүгнэж байгаагаар махнаас бусад энэ одоо зүйлийг, тэр ч байтугай сүүг хүртэл бас одоо гаднаас импортлох ийм байдалтай байгааг хэн бүхэн мэдэж байгаа байх. Тэхээр гаднаас оруулж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулах тал дээр чухам одоо юу хийх ёстой гэж та бүхэн одоо намынхаа мөрийн хөтөлбөрт тусгасан бэ? гэсэн ийм асуулт байна”, “Тэхээр хүнсний бүтээгдэхүүний энэ одоо эрүүл ахуй, аюулгүй байдал гээд ингээд ярихаар үнэндээ болбол дотоодын үйлдвэрлэлийн тухай, тэгээд ер нь эрүүл, цэвэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх тухай, энэ боломжийн тухай л ярихаас өөр аргагүй болно. Тэхээр энэ асуудлыг мөрийн хөтөлбөртөө чухам ямар байдлаар, яаж одоо тусгасан бэ? гэсэн ийм асуулт байна”, “Тэхээр хүнс хоол гэдэг маань хүний одоо эрүүл мэндийг дэмжиж хамгаалдаг чухал хүчин зүйлийн нэг гэдэгтэй бол хүн болгон санал нэг байгаа байх. Тэхээр хүнсний бодлого, аюулгүй байдлын цөм маань эргээд одоо бас эрдэнэт хүний тухай ийм асуудал аа гэж ингэж бодож байна. Тэхээр аа ... ер нь одоо хүнсний хангамж, баталгааны асуудлаар бас саналаа солилцъё гэж бодож байна. За энэ сэдэв дээр болбол саяны одоо ... түрүүнд ярьсан хоёр зүйлтэйгээ холбоотойгоор тодруулж ярих зүйлүүд ... энэ тэр ... бас хэрвээ санагдаж байвал та бүхэн энэ одоо хоёр, хоёр минутыг олгож байна”, “Тэхээр хүнсний аюулгүй байдал гэдэг энэ одоо асуудлаар танай намын, танай эвслийн одоо мөрийн хөтөлбөрт гол уриа, тийм ээ, эрхэм зорилго гэдгийг одоо товчхон хэлэх ... одоо та бүхэн юуг хэлж болох вэ?” гэж асуужээ.

Мэтгэлцээнд оролцож буй эвсэл, намуудын төлөөлөл ч сайнгүй хариулж байлаа. “Хүнсний аюулгүй байдал” сэдвээр зохиогдсон халз мэтгэлцээний сүүлчийн асуултанд хариулахдаа МУНН-ын төлөөлөл Р.Жаргалсайхан: “За тэхээр энэ хүнсний аюулгүй байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомжууд бол багадаагүй байх өө. Өнөөдөр бид бүхэн энэ зааланд суугаад ярьснаараа хүнсний

аюулгүй байдлыг шийдчихгүй л дээ. Хамгийн гол юм маань нөгөө тусгаар улсын байх ёстой нэг шинжинд энэ хүнсний аюулгүй байдал нэгдүгээрт нь явж байдаг. Энэгээрээ бас хүнсний аюулгүй байдал алдагдчихаад байдаг. Энийг одоо хянадаг, шалгадаг ийм байгууллага энэ Монгол улсад бас хангалттай байдаггүй юм шиг байна лээ. Тэгэхээр энэ хүмүүс бол бас үүргээ бас хагас дутуу биелүүлж байна уу даа гэсэн тийм бодол миний хувьд байна... Аа өөр зүйл бол ер нь одоо энэ хүнсний аюулгүй байдлыг хэрвээ бид нар... монгол хүн болгон аюулгүй оронд амьдрах ёстой л гэж ярьдаг... аюулгүй орчинд амьдрахын хамгийн гол эх сурвалж нь бидний идэж байгаа хоол хүнс, хүнсний бүтээгдэхүүн шүү дээ. Тэхээр энд 70 гаруй хувь нь импортоор авдаг гэж ярьж байх шиг байна. Үгүй байх аа, 80 хувь байдаг байх аа” гэх зэргээр ярьж, хамгийн жинтэй үгээ хэлэх хугацааг ямар ч ашиггүй өнгөрөөсөн юм. Юу ярихаа мэдэхгүй, өөрт олгогдсон хугацааг илэрхий аргацааж байсан нэр зэвшигч цөөнгүй байлаа.

Ер нь сонгуульд нэр дэвшиж буй эвсэл, намуудын төлөөлөл мэтгэлцээнийг өөрийгөө илэрхийлэх, рейтингээ өсгөх хосгүй боломж гэж хүлээн авахаас илүүтэйгээр бусдын хийж бүтээснийг үгүйсгэх, шүүмжлэх боломж гэж ойлгож байв.

Мөн мэтгэлцээний хөтлөгчийн хамгийн гол чадвар болох оролцогчдод шаардлага тавьж мөрдүүлэх тал дээр учир дутагдалтай зүйлүүд ажиглагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Хэрвээ оролцогч мэтгэлцээний дүрмийг зөрчвөл хөтлөгч түүнийг шууд таслан зогсоох ёстой байдаг бөгөөд манай хөтлөгчид сануулаад, шаардлага тавих боловч оролцогчийн амыг идэвхгүй харсан, аялдан дагах хандлага түлхүү байлаа. Оролцогчид эхний нэг-хоёр асуултанд хариулчихаад, нэвтрүүлгийн сүүл рүү хөтлөгчийн тавьсан асуултанд хариулахгүй, харин өөрийн хэлэх гэсэн зүйлийг ярихыг хичээж байсан юм. МҮОНТВ-ийн “Халз мэтгэлцээн”-ий журмаар хөтлөгч оролцогчдод хоёр минут хариулах хугацаатай тус бүр гурван асуулт тавиад өмнө дутуу ярьсан зүйлээ төгсгөх, тодруулах, дэлгэрүүлэхэд зориулж нэг минутыг нэмж олгодог. Гэтэл намууд, эвслийн төлөөлөл энэ хугацааг бусад руу дайрч давшлахад ихэвчлэн ашиглаж байв. Харин сонгуулийн хугацаа ойртох тусам ямар нэг залруулга хийхийг чухалчлах болсон юм. Ганц жишээ татахад 2008 оны 6-р сарын 24-ний “Халз мэтгэлцээн”-ээр “Хөгжлийн хөтөлбөр” намын төлөөлөл Д. Дондовсамбуу: “Надыг Орхон аймгийн тойргоос нэрээ татсан гэсэн цуу үг тархсан байна. Татаагүй болохыг сонгогчдодоо мэдэгдэж байна” гэсэн бол “Эх орон” намын төлөөлөл Д. Уламбаяр: “Манай намаас УИХ-д нэр дэвшсэн олон хүнийг нэрээ татлаа гэсэн цуурхал маш их

дэгдээсэн байна. Ийм явдал болоогүйг мэдэгдэж байна. Баянхонгорт нэр дэвшиж байгаа Жаргал, Говь-Алтайд нэр дэвшиж байгаа Оюунбилиг, Ховдод нэр дэвшиж байгаа Эрдэнэбаатар, Завханд нэр дэвшиж байгаа Мөнхбат, Дорнодод нэр дэвшиж байгаа Базаргүр нарт амжилт хүсье” гэж мэдэгдсэн.

**Сонгуулийн үеийн теле мэтгэлцээний  
хөтлөгчийн ур чадварын үзүүлэлт (тоо/хувь)**

Телевиз	Асуултын тоо	Тэгш хандлага		Дүрэм мөрдүүлэх		Асуулт оновчтой		Асуулт тодорхой	
		Тэгш	Тэгш бус	Тийм	Үгүй	Оновчтой	Оновгүй	Тодорхой	Тодорхой бус
МҮОНТВ	50	46/92	4/8	39/80	11/20	32/64	18/36	38/76	12/24
ТВ-9	42	3/7	39/93	7/17	35/83	18/43	24/57	32/76	10/24
Ийгл	18	-/0	18/100	-/0	18/100	7/39	11/61	8/44	10/56
ТВ-5	18	18/100	-/0	18/100	-/0	18/100	-/0	18/100	-/0
<b>Нийт</b>	128/100	67/52	61/48	64/50	64/50	75/59	53/41	96/75	32/25

Дээрх хүснэгтээс харахад МҮОНТВ-ийн мэтгэлцээний хөтлөгчид оролцогчдод тэгш хандах, мэтгэлцээний шаардлагыг тавьж, мөрдүүлэх, оновчтой, тодорхой асуулт тавих тал дээр хангалттай үзүүлэлттэй байна. Харин ТВ-9, “Ийгл” телевизийн сэтгүүлчид мэтгэлцээний хөтлөгчид тавигддаг шаардлагыг төдийлөн хангалттай биелүүлж чадаагүй юм.

Мэтгэлцээнд оролцогч талууд бие биенийхээ санааг давтах, шинэ мэдээ, мэдээлэл өгөхгүй байх хандлага түгээмэл байсан. Түүнчлэн улс төрийн эвсэл, намууд эдгээр мэтгэлцээнд төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа нь мэтгэлцээнд оролцогчдын бэлтгэлгүй, мэдрэмжгүй, мэдлэггүй байдал болон тэдний хариултаас илэрхий харагдаж байлаа.

**Нам, эвсэл, нэр дэвшигчид мэтгэлцээнийг ашиглаж чадсан уу?**

Мэтгэлцээн нь үзэгчдэд бодит мэдээлэл түгээх хамгийн үр өгөөж бүхий телевизийн сэтгүүл зүйн төрөл зүйлийн нэг хэлбэр юм. Мэтгэлцээнд хөндсөн сэдвээр сонгогчид аль хэр мэдээлэл, мэдлэгтэй болсоныг түүнд оролцсон талуудын яриа, хариултаар дүгнэж болно. Мөн мэтгэлцээнд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид тухайн сувгаас олгосон боломж, эфирийн цагийг хэрхэн ашигласныг судалгаанаас дүгнэж болох юм.

### **Мэдээллийн өгөөж**

Харамсалтай нь, мэтгэлцэхээр сонгосон хөгжлийн асуудлын тухай эвсэл, намуудын төлөөллийн ойлголт, өгч буй мэдээлэл хангалтгүй байлаа. Хэрэв үндсэн сэдвийн хүрээнд өгсөн нийт хариултын 31,7 хувьд нь баримт, 68,3 хувьд нь үзэл бодол давамгайлж байжээ. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээнд оролцогчид байр сууриа илэрхийлж, мөрийн хөтөлбөрөө танилцуулахдаа тодорхой баримтыг төдийлөн ашиглаагүй нь харагдав.

<b>№</b>	<b>Баримт, үзэл бодол</b>	<b>Хувь</b>
1	Баримт давамгайлсан	31,7
2	Үзэл бодол давамгайлсан	68,3
	Нийт	100%

Мэтгэлцээний бас нэг онцлог нь нэвтрүүлгийн явцад шинэ мэдээ үйлдвэрлэгч болдогт байдаг. Оролцогсад нь тэдгээр шинэ мэдээний эх сурвалж болдог. Тэдгээр эх сурвалж буюу оролцогсад хөгжлийн тулгамдсан асуудлуудаар мэтгэлцэхдээ өгүүлсэн тоо, баримтынхаа эх сурвалжийг хэр дурдаж байгааг судаллаа. Ингэхэд тэд үндсэн сэдвийн хүрээнд ярихдаа 17,2 хувьд нь л эх сурвалжийг дурдсан байна. Нам, эвслийн төлөөлөл эх сурвалжийг тодорхой заахын оронд ихэвчлэн “... гэж ярьдаг”, “... гэж сонссон” мэтчилэн хэлсэн нь итгэл үнэмшил багатай сонсогдож байв.

<b>№</b>	<b>Эх сурвалж</b>	<b>Хувь</b>
1	Дурдсан	17,2
2	Дурдаагүй	82,8
	Нийт	100%

Нөгөөтэйгүүр, энэ нь УИХ-ын сонгуулийн босгон дээр улс төрчид өөрсдийгөө таниулах, үзэл бодлоо уралдуулах чадвараар хангалтгүй байгааг харуулж байна. Сонгуульд өрсөлдөж буй нам, эвслийнхэн тодорхой баримт, эх сурвалжтайгаар мөрийн хөтөлбөртөө тусгагдсан зүйлийг илэрхийлж чадаагүй төдийгүй, нийгмийн

хөгжлийн аливаа асуудлыг шийдвэрлэх гарц, арга замыг сайн тооцоогүй, зөвхөн хийнэ, биелүүлнэ, бид арилгана, ингэх ёстой, тэгэх ёстой гэсэн байр сууринаас хандаж байлаа. Үүний улмаас нам, эвсэл, улс төрийн хүчнээс хүлээж буй нийгмийн хүлээлт, олон нийтийн хүсэл сонирхлыг хангахуйц мэдээллийн багтаамжтай мэтгэлцээн төдийлөн өрнөсөнгүй. Бие биенээ давах гэсэн, хэн нэгнээс бурууг хайсан, шүүмжилсэн, үгүйсгэсэн өнгө аяс нэвтрүүлгүүдэд зонхилж байв.

### **Намууд мөрийн хөтөлбөрөө танилцуулах боломжоо хэрхэн ашигласан бэ?**

Хөтлөгчийн асуултанд намын мөрийн хөтөлбөрөө үндэслэж хариулсан байдал нь 33,3 хувь байгаа бол өөрийн хандлага, үзэмжээр, өөрөөр хэлбэл тойм төдий хариулсан байдал 66,7 хувьтай байна.

Жич: Бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө танилцуулсныг намын мөрийн хөтөлбөр танилцуулсантай жишиж үзэв.

<b>№</b>	<b>Мөрийн хөтөлбөр, өөрийн хандлага</b>	<b>Хувь</b>
1	Намынхаа мөрийн хөтөлбөрийг танилцуулсан	33,3
2	Өөрийн хандлагыг илэрхийлсэн	66,7
	Нийт	100%

Оролцогсдын хөтлөгчийн асуултанд тодорхой хариулсан байдал мөн л хангалтгүй байна. Энэ нь нэг талаас хөтлөгчдийн тавьж буй асуулт хэт нуруу, ойлгомжгүй, нэг зэрэг хэд хэдэн зүйлд хариулт эрэлхийлсэнтэй холбоотой боловч нөгөөтэйгүүр оролцогч бэлтгэл муутай, сэдвээ эзэмшээгүй байгаагийн үр дагавар юм. Ийм тохиолдолд оролцогч бусад руу дайрах, огт өөр зүйл ярих зэргээр мэтгэлцээний шаардлагыг зөрчих нь түгээмэл ажээ. Хувиар авч үзвэл үндсэн сэдвийн хүрээнд оролцогсдын 58,8 хувь нь асуултанд тодорхой хариулсан бол 41.2 хувь нь тодорхой хариулсангүй.

<b>№</b>	<b>Хариулт</b>	<b>Хувь</b>
1	Тодорхой хариулсан	58,8
2	Тодорхой хариулаагүй	41,2
	Нийт	100%

Нэр дэвшигч, нам, эвслийн төлөөлөгчид асуултад хариулахдаа сэдвээсээ халих, өөрийн үзэл бодлыг тулгах, туйлшрах, асуудалд хамааралгүй зүйл ярих нь түгээмэл байлаа.

## V. Дүгнэлт

Энэ удаагийн сонгуулийн үеэр манай гол телевизүүд түүхэнд байгаагүй олон мэтгэлцээн зохион байгуулжээ. Мэтгэлцээн зохион байгуулсан телевизүүд сонгуулийн үеэр үзэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, сонгогчдод хөгжлийн гол асуудлаар нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн байр суурийн тухай мэдээлэл түгээсэн байна.

Гэхдээ мэргэжлийн зарим алдаа, доголдол гарсан байна. Тухайлбал:

- УИХ-ын сонгуулийн сурталчилгааны кампанит ажлын үеэр цацагдсан теле мэтгэлцээнд оролцогчдод тэгш боломж олгоогүй, шударга хандах зарчмыг алдагдуулсан тохиолдол цөөнгүй байлаа. Тухайлбал: “Ийгл” телевизийн мэтгэлцээнд оролцогчдод тодорхой хугацаанд хариулахыг сануулаагүйгээс оролцогч бүр өөр өөр хугацаанд хариулах, мэтгэлцээний дундуур олон тооны реклам, тэр ч байтугай улс төрийн сурталчилгаа явуулах зэрэг теле мэтгэлцээний үндсэн шаардлагуудыг зөрчсөн тохиолдол цөөнгүй байна. Харин “ТВ-9” телевизийн хувьд мэтгэлцээний хөтлөгч нь оролцогч болгонд харилцан адилгүй асуулт тавих, мөн хариулах дараалал байхгүйгээс үзэмжээрээ хэн нь эхэлж ярихыг заах, оролцогчдоосоо их ярих, оролцогчийн хариултыг илэрхий, шууд дэмжих зэргээр шаардлагуудыг зөрчиж байв.

- Халз мэтгэлцээнүүдийг асуултаар нь задалж үзэхэд нэг нэвтрүүлэгт дунджаар 3-4 асуулт тавигдаж байснаас оновчгүй, тодорхой биш асуулт цөөнгүй байлаа. Тухайлбал: нийт 27 мэтгэлцээнд 128 асуулт тавигдсаны 41 хувь нь оновчгүй, 25 хувь нь тодорхой бус байв. Хөтлөгчдийн тавьсан ихэнх асуултыг сонсоод яг ийм зүйл асуулаа гэж ойлгоход бэрх, харин нэг иймэрхүү л юм асууж байх шиг байна гэж тойм төдий барагцаалан төсөөлөх хэмжээнд л боловсруулагдсан байлаа. Тодорхойгүй асуулт тодорхой хариулт өгөхөд хүндрэл учруулж байв. Мөн асуулт нь өгөгдсөн хоёр минутанд хариулж багтахааргүй хэтэрхий өргөн байсан нь нэвтрүүлгийг зохион байгуулж буй хүмүүсийн туршлага, арга барил дутмаг байгааг харуулж буй юм.

- Мэтгэлцээнт нэвтрүүлгээр үндсэн сэдвийн хүрээнд хамгийн их дурдагсан арван сэдэв бол уул уурхай, ашигт малтмал (11,3%); хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага (10,3%); авлига, хүнд суртал (7,2%); байгаль, экологи (6,7%); хүнсний аюулгүй байдал (5,4%); мөнгөний ханш уналт (4,6%); үнийн хөөрөгдөл (4,6%); эдийн засгийн хөгжлийн асуудал (4,2%); газар өмчлөл, газрын хууль (3,8%); ажлын

байр (3,0%) зэрэг байсан ба дам хэлбэрээр хамгийн олон дурдагдсан арав нь хууль эрх зүй, шударга ёс, хариуцлага (16,5%); авлига, хүнд суртал (9,8%); нийгмийн халамж (6,9%); үндэсний үйлдвэрлэл (5,6%); уул уурхай, ашигт малтмал (5,5%); ядуурал (5,4%); иргэний эрх, эрх чөлөө (5,3%); байгаль, экологи (4,3%); эдийн засгийн хөгжлийн асуудал (4,1%); ажлын байр (3,6%) гэх мэт сэдэв байлаа.

- Хөгжлийн тулгамдсан асуудлуудын тухай эвсэл, намуудын төлөөллийн ойлголт, өгч буй мэдээлэл хангалтгүй байлаа. Хэрэв үндсэн сэдвийн хүрээнд өгсөн нийт хариултын 31,7 хувьд нь баримт давамгайлж байсан бол 68,3 хувьд нь үзэл бодол давамгайлж байжээ. Өөрөөр хэлбэл мэтгэлцээнд оролцогчид байр сууриа илэрхийлж, мөрийн хөтөлбөрөө танилцуулахдаа тоо баримтыг төдийлөн ашиглахгүй байна.

- Улс төрийн намууд, эвслийн төлөөлөл хөгжлийн тулгамдсан асуудлуудаар мэтгэлцэхдээ өгүүлсэн тоо, баримтынхаа эх сурвалжийг 17,2 хувьд нь л дурдсан нь хангалтгүй үзүүлэлт юм. Мэтгэлцээнд оролцогчид эх сурвалжийг тодорхой заахын оронд ихэвчлэн "... гэж ярьдаг", "... гэж сонссон" мэтчилэн буух эзэнгүй, буцах хаяггүй орхиж байна.

- Хөтлөгчийн асуултанд намын мөрийн хөтөлбөрөө үндэслэж хариулсан байдал нь 33,3 хувь байгаа бол өөрийн хандлага, үзэмжээр хариулсан байдал 66,7 хувьтай байна.

- Асуултанд тодорхой хариулсан байдал хангалтгүй байна. Энэ нь нэг талаас хөтлөгчдийн тавьж буй асуулт хэт нуршуу, ойлгомжгүй, нэг зэрэг хэд хэдэн зүйлд хариулт эрэлхийлсэнтэй холбоотой боловч нөгөөтэйгүүр оролцогч бэлтгэл муутай, сэдвээ эзэмшээгүй байгаагийн үр дагавар юм. Ийм тохиолдолд оролцогч бусад руу дайрах, огт өөр зүйл ярих зэргээр мэтгэлцээний шаардлагыг зөрчих нь түгээмэл ажээ. Хувиар авч үзвэл үндсэн сэдвийн хүрээнд асуултанд тодорхой хариулсан тохиолдол 58,8 хувь, тодорхой хариулалгүй өнгөрсөн тохиолдол 41,2 хувьтай байна.

- Сонгуульд өрсөлдөж буй нам, эвслийнхэн тодорхой баримт, эх сурвалжтайгаар мөрийн хөтөлбөртөө тусгагдсан зүйлийг илэрхийлж чадаагүй төдийгүй, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарц, арга замыг сайн тооцоогүй, зөвхөн хийнэ, биелүүлнэ, бид арилгана, ингэх ёстой, тэгэх ёстой гэсэн байр сууринаас хандаж байлаа. Нам, эвсэл, улс төрийн хүчнээс хүлээж буй нийгмийн хүлээлтийг хангахуйц, олон нийтийн хүсэл сонирхлыг хангахуйц мэдээллийн багтаамжтай мэтгэлцээн төдийлөн өрнөсөнгүй. Сонгуульд нэр дэвшиж буй эвсэл, намуудын төлөөлөл мэтгэлцээнийг өөрийгөө илэрхийлэх,

рейтингээ өсгөх хосгүй боломж гэж хүлээн авахаас илүүтэйгээр бусдын хийж бүтээснийг үгүйсгэх, шүүмжлэх боломж гэж ойлгож байв.

- Сонгогчдод зориулсан сонгуулийн кампанийн үеийн мэтгэлцээнүүд дотроос МҮОНТВ-ээс зохион байгуулсан “Халз мэтгэлцээн” нь телевизийн мэтгэлцээний стандарт, шаардлагад ойртсон нэвтрүүлэг болж чаджээ.

### **Зөвлөмж**

1. Хөгжлийн тодорхой асуудлуудыг хөндөхдөө ерөнхий бус нарийвчилсан, өнцгөө сайн тодорхойлох
  2. Хөгжлийн тодорхой асуудлаар сэтгүүлчдийн мэдлэгийг дээшлүүлэх
  3. Мэтгэлцээний загвар, хэлбэр, бүтэц, стандарт, зарчмын тухай мэдлэгийг дээшлүүлэх
  4. Хойшид мэтгэлцээн хийхдээ дор дурдсан зүйлийг анхаарах. Тухайлбал:
- Мэтгэлцээнийг хөтлөгчид сэдвийнхээ хүрээнд асуултыг урьдчилан боловсруулж, цаасан дээр буулгасан байвал зохилтой. Энэ нь ихэнх хөтлөгчид асуултыг сэдвийнхээ хүрээнд толгойндоо боловсруулснаас болж яг тайзан дээр гарч ирэхээрээ балмагдаж, хэт олон зүйл нурших, асууж байгаа, ярьж байгаа нь ойлгогдохгүй болох, асуултаа үл ойлгогдох хэлбэрээр тавих, эсвэл олгогдсон хугацаанд хариулж амжихааргүй өргөн хүрээний зүйл асуух зэрэг дутагдал түгээмэл ажиглагдаж байгаатай холбоотой. Ойлгомжгүй, хэл найруулгын болон учир зүйн алдаа мадагтай асуулт нь мэтгэлцээнд оролцогчийг тэс өөр зүйл ярих, сэдвээс халих, бусад руу дайрч давшлах зэрэг зохисгүй үйлдэл хийхэд хүргэж байна. Түүнээс гадна сэтгүүлчийн тавьсан ойлгомжгүй асуултнаас болж хамгийн гол нь сонгогчид нэр дэвшигчийн талаар огт төсөөлөлгүй хоцрох, тэр ч байтугай буруу ойлголт авах аюултай байна.
  - Хөтлөгч нэвтрүүлгийнхээ эхэнд мэтгэлцээний дүрмийг зайлшгүй танилцуулж байх хэрэгтэй. Түүнчлэн оролцогчдын хариулах дараалал, хугацааг тогтоохгүй бол шударга хандах, тэгш боломж олгох шаардлага алдагдаж, хэн хүссэн нь түрүүлж ярих, хичнээн ч удаан хамаагүй хариулах, улмаар нэг нь асуултанд хариулт өгч чадахгүй хоцроход хүргэж байна.
  - Мэтгэлцээнд нэр дэвшигчдийг урьж оролцуулахдаа улс төрчийн хувьд ойролцоо туршлагатай хүмүүс байхаар тооцоолох нь зүйтэй. Эс тэгвэл мэтгэлцээний ширээний ард УИХ-д сонгогдож байсан хашир туршлагатай парламентчид сонгуульд анх удаа бие дааж нэр дэвшиж байгаа хүмүүстэй

хамт суухад хүрч буй юм. Энэ нь хүнд жингийн боксчныг хөнгөн жингийн боксчинтой тулалдуулснаас өөрцгүй. Ингэсэн тохиолдолд халз мэтгэлцээн өрнөхгүй байх талтай.

- Оролцогч мэтгэлцээний дүрмийг зөрчиж, хэн нэгэн рүү дайрч, шүүмжилж эхлэхэд хөтлөгч нэн даруй таслан зогсоох эрхээ эдлэх хэрэгтэй байгаа юм. Эс тэгвэл шүүмжлүүлсэн нэр дэвшигч залруулга хийх, хариу няцаалт өгөхийг чухалчилж, бүхий л анхаарал, цагаа үүнд чиглүүлж байна. Эцсийн дүндээ сонгогч мэтгэлцээн бус, хэрүүл үзэхэд хүрч байна.
- Хоёр хөтлөгчтэй мэтгэлцээнд тэдний үүргийг нарийн тодорхой болгох. Учир нь, хөтлөгчдийн хэн нь чиглүүлэх нь тодорхойгүй болж, заримдаа өөр хоорондоо зөрчилдсөн асуулт тавих ч тохиолдол гарч байв.
- Зарим телевиз мэтгэлцээнийг сонирхолтой болгох үүднээс утсаар үзэгчдээс санал, асуулт авдаг. Гэтэл холбогдсон үзэгч оролцогчдын хэн нэгнийг нэр зааж илэрхий дэмжиж, эсвэл шүүмжилж, дайрч давшлах зэргээр зохимжгүй авирлахаас гадна тодорхой нэг хүнд асуулт тавих, хүссэн зүйлээ цагт баригдалгүй ярих зэргээр мэтгэлцээний мөн чанарыг эвдэж байна. Ер нь ч мэтгэлцээнд оролцогчдын үзэл бодол, мөрийн хөтөлбөр сонгогчдод чухал болохоос хэн нэг үзэгчийн байх суурь ач холбогдолгүй билээ.
- Хариулах хугацаа дууссаны дараа микрофон шууд унтарч байхаар зохион байгуулах нь зүйтэй. Микрофон нээлттэй байснаар оролцогчид хоорондоо маргалдах, хугацаа нь дуусчихаад байхад хэлэх гэсэн зүйлээ дуусгана гээд дайрах тохиолдол гарч байна. Микрофон шууд унтарч байхад хөтлөгч цаг дууссаныг сануулж, дүрэм барихыг шаардаж, маргааны уур амьсгал бий болгохоос зайлсхийх боломжтой юм. Хөтлөгчид оролцогч бүрт цаг дууссаныг нь сануулж, яриаг нь зогсооход багагүй хугацаа зарцуулж байна. Микрофоны асуудлыг шийдсэнээр цаг хэмнэх боломж гарч ирнэ.
- Мэтгэлцээний дундуур реклам, тэр тусмаа улс төрийн намуудын сурталчилгаа явуулдаг нь мэтгэлцээний тэнцвэртэй, шударга байх зарчмыг алдагдуулж байна.
- Нэр дэвшигчдийг сонгогчдод хамгийн ерөнхий байдлаар таниулахын тулд наанадаж 3-4 асуулт шаардлагатай байна. Гэтэл зарим мэтгэлцээн 1-2 асуулт тавьж, хариулт авснаар өндөрлөх ажээ. Ийм мэтгэлцээн үзсэн сонгогч нэр дэвшигчдийн талаар ямар ч ойлголтгүй шахам өнгөрч байгаа бөгөөд мөн чанартаа сонгуулийн хуулийн дагуу нэр дэвшигчдэд эфирийн цаг өгсөн гэж ам таглах аргацаасан зүйл юм.